

THE PRESENT SITUATION OF THE TOURISM SECTOR AND INVESTMENT OPPORTUNITIES IN MONGOLIAN TOURISM

**Mr. Ts.Tsengel,
Minister for Road, Transport and Tourism
at the Investment Forum**

Dear distinguish guests and investors, I would like to congratulate on the 800th anniversary of establishment of the Great Mongolian State. This is my great pleasure to present you about Mongolian tourism sector today.

Since the 1990s tourism sector in Mongolia has been privatized and with the country's rapid transformation to a market economy tourism has developed significantly.

In 1995 the government resolved basic directions for the tourism development between 1995 and 2005. In 2000 Tourism Law was adopted by the Parliament of Mongolia, which became basic of legal environment of the tourism development. In addition, from 1998 to 1999, the 'Mongolian Tourism National Programme Master Plan' was formulated by the TACIS programme of the European Union and the JICA from the Japanese government. It is seen as a grand step to develop Mongolian tourism in conjunction with the development of world tourism.

Public and non-public organizations and private entities are working actively to realize basic objectives for Mongolia to become a centre of international tourism. The Mongolian government has put forward objectives to develop tourism, as a one of priority sectors of the Mongolian economy: the income of the tourism sector reached 210 million USD, forming 10 per cent of the Gross Domestic Production. In recent years, for the stimulation of international cooperation our ministry contracted for the cooperation in tourism sector development between the ministries and government of 10 countries. In 2005 the ministry in assistance of USAID has established first tourist information centre in Ulaanbaatar and now it has branches in Tokyo and Beijing.

For the implementation of Tourism Law there have been developed over 10 standards and decrees to such as hotel and tourist camp classification, tourism transport standard, tour guide certification and so on.

Mongolian tourism runs by 100% private entities and government supports for their better business environment and took the following actions such as to abolish licensing in tourism business since 2002 and to issue visa in international border points to citizens of the country where no Mongolian embassy and counsellor section has.

As a member of the World Tourist Organization, Mongolia has been actively participating in its main events, particularly the large scale tourism exhibitions in order to promote Mongolia in foreign countries and increase the number of foreign tourists to Mongolia. Those exhibitions include the WTM in Great Britain, ITB in Germany, MITT in Russia, KOTFA in Korea, BITF in China, and JATA in Japan.

2003 was officially called the 'Year of Visit Mongolia' and 2004 was officially called the 'Year of Discover Mongolia' based on the experiences of countries where tourism promotion in high level.

As a result of that, the government organized many important works in the following directions:

- Advertise Mongolia to foreign countries as well as possible
- Form a good working environment for developing tourism
- Improve the quality of service
- Provide for the safety of tourists
- Protect Mongolian historical places

Mongolian government exempted of VAT on inbound tourism, considering its effect on national economy and ability to earn foreign currency and exempt of custom tax on import of winter tourism facilities in order to extend the season.

Number of tourists to Mongolia increases 15-20% each year and in 2005 the total number was estimated at 338,717. For the first seven months of 2006, 195,000 tourists came to Mongolia, a figure which shows that the number increased by 10% compared with the same period of 2005.

Today, there are over 600 tour operators, 320 hotels, 200 tourist camps, and 182 guides, who have been certified. Over 40 state and private universities prepare specialists for tourism mainly in managerial level.

All these result shows that business and legal environment for tourism developed well in Mongolia however there is many more action to take for sustainable tourism.

Having a low environmental impact, and unlimited resources, safeguarding of international peace, creation of more jobs tourism is called a 'smokeless industry'. That is why Mongolian governments enlisted tourism in its priority sector to take special obligation. However tourism depends on the political and economic situation such as war, poverty, natural disaster, infectious disease, and international terrorism, which are difficult to predict in advance. Previous bad experiences in many countries demonstrate that tourism is a very sensitive branch of the economy that needs special planning.

According to researchers, our country has a capacity to receive 450,000-500,000 tourists a year. The preparation of tourism for these kinds of numbers has been implemented in the frame of the policy based on the flow of World Tourism directed to the Asian and Pacific Ocean region.

Pristine nature is a main resource of Mongolian tourism. So the main policy for the sustainable development of tourism is in keeping the ecological balance, protecting nature, improving the infrastructure, and developing human resources. Today although there are currently not enormous numbers of tourists in Mongolia, we need to look critically at, and take care of the ecological balance in the main regions of tourism such as Gorkhi-Terelj and Khuvsgul Lake.

The main achievement in the past was to create common image of Mongolia which is exotic and peaceful destination with hospitable people pleasant for foreign investment. According to

the statistics 70% of tourists tend to come second time and 30% of tourists come more than 2 times to Mongolia.

We are working on the following to consolidate Mongolian tourism with international pace:

- Develop winter tourism to reduce its seasonality, produce new tourist products and itineraries according to the interests of tourists from neighbouring countries.
- Increase receiving capacity for tourists and improve marketing policy to be effective on target markets
- Distribute of income from tourism in the countryside, in order to support social problems.

Mongolia has huge potential for ecological, historical, cultural tourism development, where needs to establish more recreational and holiday centers with world standards. There are not any additional or optional activities and adventures if we do not include horse and camel riding or boating. Thus we need more facilities for adventure tourism. However there were winter tourism development initiatives to extend season from June to middle of September, still there is no significant results.

It is hard to clearly define investment figures in tourism in the past I would like to point out that 95% of tourist camps out of 180 are established by the local investors and so far we have not got international chain of hotels and other services. Last 5 years there were significant interest of foreign investments in tourism. In 2006 there began following grand projects such as “Morin nuur” by Belgian company Imperial gold with 250 million USD budget, “Shangri La hotel” by Mongolian MCS company in collaboration of Singaporean partner with a budget of 70 million USD, “Hilton Mongolia” by Mongolian Star Estates company with a investment of 45 million USD and “Park Savoy Hotel” by Mongolian New tour company with the investment of 54 million USD.

Once these 5 star establishments are in operation there will be less problem in accommodation for tourists.

90% of tourism takes place in countryside of Mongolia and nature is the Mongolian tourism basis. Currently, tourism is intensive in areas of Ulaanbaatar, SouthGobi, Uvurhangai and Huvsgul provinces where covered by road, electricity and communication network development. We are planning to develop historical tourism in eastern provinces such as Hentii, Dornod and adventure tourism in western provinces as Bayan-Ulgii, Hovd, and Uvs.

I believe we will see Mongolian tourism to be major sector of the social economy where works strong skilled people, who provides world standards services and where will be ecotourism and adventure complexes in the well balanced nature. For this I hope for your kind cooperation.

Thank you very much for your attention.

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ НЬ

Монголд хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын
Аялал жуулчлалын салбар хуралдаанд ЗТАЖ-ын
сайд Ц.Цэнгэлийн тавих илтгэл

Аялал жуулчлалын салбар хуралдаанд оролцож буй хүндэт зочид төлөөлөгчид, хөрөнгө оруулагчид та бүхэнд Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн түүхт ойн мэнд хүргэе.

Өнөөдөр та бүхэнтэй уулзаж Монгол улсын аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдлын талаар мэдээлж, санал бодлоо солилцож байгаадаа баяртай байна.

1990-ээд оноос аялал жуулчлалын салбар хувьчлагдаж, чөлөөт өрсөлдөөнт зах зээл бий болсноор түргэн хурдацтай хөгжиж байна. 1995 онд Засгийн газраас Аялал жуулчлалыг 1995-2005 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг тогтоож, 2000 онд УИХ-аас Аялал жуулчлалын хуулийг батлан гаргасан нь салбарын эрх зүйн болон бодлогын орчинг бүрдүүлэхэд томоохон алхам болсон юм. 1998-1999 онуудад Европын холбооны Тасис хөтөлбөр, Япон улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр Монголын аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр Мастер төлөвлөгөөг боловсруулсан нь аялал жуулчлалын салбарыг дэлхийн аялал жуулчлалын хөгжилтэй уялдуулан хөгжүүлэхэд чиглэгдсэн чухал ажил болсон. Монгол орныг олон улсын аялал жуулчлалын сонирхол татсан бүс нутаг болгох салбарын эрхэм зорилтыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд идэвхтэй ажиллаж байна.

Монгол улсын Засгийн газар аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилт дэвшүүлэн ажилласны дүнд салбарын орлого ДНБ-ний 10 орчим хувийг бүрдүүлдэг боллоо.

Аялал жуулчлалын гадаад харилцаа сүүлийн жилүүдэд өргөжиж арав гаруй улс оронтой хамтран ажиллах Засгийн газар, яамд хоорондын хэлэлцээр байгуулснаас гадна 2005 онд байгуулагдсан аялал жуулчлалын мэдээллийн “Гийчин” төвийн салбарууд Япон, БНХАУ-д нээгдээд байна. Монгол улс Д элхийн аялал жуулчлалын байгууллагын үйл ажиллагаанд гишүүн орны хувьд идэвхтэй оролцож байна.

Хувийн хэвшилд тулгуурласан аялал жуулчлалын салбар манай улсад хөгжиж эхлээд удаагүй боловч эрхзүйн орчин үндсэндээ бүрдээд байна. УИХ-аас 2000 онд Аялал жуулчлалын тухай хуулийг батлан гаргаснаас хойш хуульд нийцүүлэн гаргасан 10 гаруй дүрэм журам, стандартууд мөрдөгдөж байна.

Аялал жуулчлалын салбар дахь хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор 2002 оноос хойш аялал жуулчлал эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, манай улсын элчин сайдын яам, консулын газар, өргөмжит төлөөлөгч байхгүй орноос ирж байгаа жуулчдад хилийн боомтууд дээр виз олгодог болсон явдал нь энэ салбар эрчимтэй хөгжих үндсэн нөхцөл болж байна.

Монгол орныг гадаадад сурталчлах, гадаадын жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалын чиглэлээр ИБУИНВУ, ХБНГУ, ОХУ, БНСУ, БНХАУ, Япон, Тайвань болон бусад орнуудад зохион байгуулагдаж буй томоохон үзэсгэлэн яармагт тогтмол оролцдог боллоо. Аялал жуулчлал өндөр хөгжсөн орнуудын туршлагыг үндэслэн Монгол улсын Засгийн газраас 2003 оныг Монголд зочлох жил болгон зарлаж монгол орныг гадаадад өргөн хэмжээгээр сурталчлах, аялал жуулчлал хөгжих таатай орчин бүрдүүлэх, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, монгол орны түүх, дурсгалын зүйлсийг хамгаалах чиглэлээр бодитой ажлуудыг зохион байгуулж, хүрсэн амжилт ололтоо бататгах, салбарын хөгжлийг түргэсгэх зорилгоор Зочлох жилийг 2004 онд үргэлжлүүлэх шийдвэрийг гаргасан.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, санхүүгийн чадавхийг сайжруулах зорилгоор НӨАТатвараас чөлөөлөх, өвлийн болон тусгай сонирхлын аяллын зарим техник хэрэгслийг импортоор оруулж ирэхэд гааль, НӨАТатвараас чөлөөлөх шийдвэрүүдийг гаргасан нь төр засгийн зүгээс үзүүлж байгаа бодитой дэмжлэг юм.

Сүүлийн жилүүдэд монголд ирж байгаа гадаадын жуулчдын тоо, тэдэнд үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, тур операторуудын тооны өсөлт нь энэ салбарын эрхзүйн таатай орчин бүрдсэнийг гэрчлэх гол үзүүлэлт юм.

Сүүлийн жилүүдэд монголд ирсэн жуулчдын тоо жил бүр тогтмол өсч, 2005 онд 338715 жуулчин ирсэн нь 2004 оноос 12,7 хувиар өссөн үзүүлэлт байв. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 600 тур оператор компани, 320 зочид буудал, 180 жуулчны бааз, 182 үндэсний аяллын зэрэглэлтэй хөтөч-тайлбарлагч ажиллаж төрийн болон хувийн хэвшлийн 40 орчим их, дээд сургуулиуд салбарын мэргэжилтэн бэлтгэж байна.

Улс түмний хамтын ажиллагааг бэхжүүлэн, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, ажлын байрыг ихээр бий болгодог, байгаль орчинд хор хөнөөл багатай хязгааргүй нөөцтэй “Утаагүй үйлдвэрлэл” болохын хувьд аялал жуулчлалыг Монгол улсын эдийн засгийн нэг гол салбар болгон хөгжүүлэх шаардлагатай байгааг үе үеийн Засгийн газрууд тодорхойлж, хөгжүүлэх талаар олон чухал алхмуудыг хийсэн.

Аялал жуулчлал нь улс төр, эдийн засгийн хямрал, дайн дажин, ядуурал, байгалийн гамшиг, халдварт өвчин, олон улсын терроризм зэрэг урьдчилан таамаглах боломжгүй хүчин зүйлсээс шууд хамааралтай ихээхэн эмзэг салбар болохыг өнгөрсөн хугацаанд дэлхий дахинд болж буй үйл явдлууд харуулж, түүнийг хохирол багатайгаар гэтлэн давж, урьдчилан сэргийлэхэд улс орнууд хэзээ хэзээнээс илүү анхаарч, бодлогоо төлөвлөх шаардлагатай болж байна. Мэргэжилтнүүдийн тооцоолж байгаагаар манай улс жилдээ 450-500 мянган жуулчин хүлээн авах хүчин чадалтай. Дэлхийн жуулчлалын урсгал Ази, Номхон далайн бүс нутагт хүчтэй нэмэгдэх төлөв ажиглагдаж байгаад дүгнэлт хийж жуулчдын “Үер”-т хийх бэлтгэлийг одооноос тодорхой бодлогын хүрээнд хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй юм. Энэ асуудалд гадаадын хөрөнгө оруулалтыг татах замаар жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал онцгой байр суурь эзэлнэ.

Монгол орны онгон байгаль нь экотуризмын гол нөөц учраас экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр жуулчдыг хүлээн авах, улмаар байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх замаар улс орны эдийн засгийг хөгжүүлэх нь төрөөс аялал жуулчлалын талаар баримталж байгаа гол бодлого юм. Өнөөдөр манай орон жуулчдын хөлд төдийлөн дарагдаагүй ч аялал жуулчлалын гол бүс нутаг, тухайлбал Горхи-Тэрэлж, Хөвсгөл нуурийн байгалын цогцолбор газар нутгийн экологийн байдалд шүүмжлэлтэй хандах шаардлага гарч эхэллээ.

Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын салбарт бидний олсон хамгийн чухал амжилт бол Монгол бол сонирхолтой аялал жуулчлалын бүс нутаг болохоос гадна тайван амгалан, гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдсэн орон гэдэг төрхийг бүрдүүлж чадсанд оршино. Судалгаагаар монголд ирсэн жуулчдын 70 орчим хувь нь дахин ирдэг, түүний 30 орчим хувь нь 2-оос дээш удаа манай улсад аялдаг байна.

Дэлхийн аялал жуулчлалын хөгжлийн хандлага, бодлоготой уялдуулан монголын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар дараах бодлого, чиглэлүүдийг тодорхойлон ажиллаж байна. Үүнд:

- Аялал жуулчлалын үйлдвэрлэлийг улирлын эрхшээлээс гаргах ялангуяа өвлийн аяллыг хөгжүүлэх замаар хөрш орны жуулчдын сонирхолд нийцсэн шинэ бүтээгдэхүүн, аяллын маршрут бий болгох
- Гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх, хөрөнгө оруулагчдыг татах
- Монгол орны аялал жуулчлалын сурталчилгааг тодорхой зах зээлд чиглэсэн өргөн далайцтай, тогтмол явуулах
- Салбарын үйлчилгээний чанар, соёлын түвшинг сайжруулах зорилгоор хүний нөөцийг хөгжүүлэх, их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрүүдийг гадаад орнуудын түвшинд хүргэх
- Монгол оронд түүх, соёл, экотуризм хөгжих давуу тал, онцлогийг харгалзан хөдөө, орон нутагт аялал жуулчлалаас ордог орлогын зохих хувийг хувиарлах замаар тэнд ажиллагсдын нийгмийн болон байгаль хамгаалах асуудлыг шийдвэрлэх зэрэг болно.

Монгол оронд байгаль, түүх, соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх арвин нөөцтэй боловч амралт, аялал жуулчлалын дээд зэрэглэлийн цогцолбор, хотхонуудыг байгуулах шаардлагатай байна. Орон нутагт байдаг жуулчны баазууд морь, тэмээ унуулах үйлчилгээг эс тооцвол аяллын нэмэлт үйлчилгээний төрөл, зүйл хангалтгүй байна. 6 сараас 9 сарын дунд хүртэл үргэлжилдэг жуулчны улирлыг уртасгах зорилгоор өвлийн спорт, амралтын төвүүд байгуулах санаачлагууд гарч байгаа боловч одоогоор тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Манай улсын хувьд жуулчин хүлээн авах байршлын хэрэгслийн хүчин чадал муу, мэргэжилтэй боловсон хүчний хэрэгцээ их, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл хомс байгаа боловч эдгээр асуудлыг ойрын хугацаанд шийдвэрлэх боломжтой.

Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлалын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалтын тоог тодорхойлох амаргүй байдаг боловч одоо байгаа 180 орчим жуулчны баазуудын 95%-ийг дотоодын хөрөнгө оруулалтаар байгуулсан юм.

Одоо 2006 онд Нью тур ХХК-ийн 54 сая ам.долларын хөрөнгө оруулалттай 5 одтой Парк Савой зочид буудал, Эм Си Эс ХХК-ийн Шангри-Ла зочид буудал, Стар Эстэйтс компанийн 45 сая ам.долларын хөрөнгө оруулалттай Хилтон зочид буудал, Имperiал Гоулд компанийн 250 сая ам.долларын хөрөнгө оруулалттай “Морин нуур” зэрэг цогцолборуудыг байгуулах ажиллагаа эхлээд байна. Түүнчлэн дотоодын хөрөнгө оруулалтаар томоохон аялал жуулчлалын цогцолборууд байгуулагдаж байна.

Нийт жуулчлалын 90% хөдөөд явагддаг бөгөөд монголын аялал жуулчлалын гол цөм нь хөдөө орон нутаг юм. Одоогоор зам, цахилгаан, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн сүлжээгээ дагаад Улаанбаатар хотын орчим, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл зэрэг аймгуудад аялал жуулчлал түлхүү хөгжиж байгаа боловч Зүүн бүсийн Хэнтий, Дорнод, Баруун бүсийн Баян-Өлгий, Ховд, Увс зэрэг аймгуудад аялал жуулчлал хөгжих өргөн боломжтойг байгааг цохон тэмдэглэхийг хүсч байна.

Монголын аялал жуулчлалыг ойрын ирээдүйд байгалийн унаган төрхөө хадгалсан хүрээлэн байгаа орчинд дэлхийн төвшинд хүрсэн үйлчилгээтэй, адал явдалт, спорт аялалын дээд зэрэглэлийн төвүүдтэй, чадварлаг боловсон хүчинтэй, улс орны нийгэм, эдийн засагт бодит хувь нэмэр оруулдаг бие даасан салбар болгохын төлөө та бүхэнтэй хамтран ажиллахад таатай байх болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.